



ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР БАЙГУУЛАХТАЙ
ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХЭД
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

ГЭРЭЭНИЙ ДУГААР № 2


“БОЛДГЯНТБОЛД” ХХК

2021 оны сарын өдөр

№.....



ДАРГЫН ОРЛОГЧ



БАГЛАВ
АЙМГИЙН ЗАСАГ

Г.ЧИНБАТ

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХ, ҮЙЛДВЭР
БАЙГУУЛАХТАЙ ХОЛБОГДСОН ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, АЖЛЫН
БАЙР НЭМЭГДҮҮЛЭХЭД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Гэрээний дугаар № 2

2021 он дугаар сарын өдөр

<p>ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ЕСӨНБУЛАГ СУМ</p> <p>Монгол Улс, Говь-Алтай аймаг, Есөнбулаг сумын Засаг дарга, түүний Тамгын газар</p> <p>Регистрийн дугаар: 9014748.</p> <p>Эрх бүхий төлөөлөгч: Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг дарга А.Алтанхуяг Гар утас: 976 99016669 Е-шуудан:</p>	<p>“ БОЛДГЯНТБОЛД ” ХХК</p> <p>Регистрийн дугаар: 5884098</p> <p>Эрх бүхий төлөөлөгч: Ерөнхий захирал Х.Олонболд</p> <p>Гар утас: 976 97101077 Е-шуудан: bolds.bolds1999@gmail.com</p>
---	--

ГЭРЭЭНИЙ ЗҮЙЛ:	ХАРИЛЦАН ХАМТЫН АЖИЛЛАГАА
АЖЛЫН ТАЛБАР:	МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ, ЕСӨНБУЛАГ СУМ

ГОЛ НӨХЦӨЛ	
НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	
1.1. Нэг талаас Говь-Алтай аймгийн Засаг дарга О.Амгаланбаатар, түүнийг төлөөлж Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Засаг дарга А.Алтанхуяг (цаашид “Засаг дарга” гэх), нөгөө талаас ашигт малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшигч “ Болдгянтболд ” ХХК-ийн Ерөнхий захирал Х.Олонболд (цаашид “Тусгай зөвшөөрөл эзэмшигч” гэх) нар (цаашид хамтад нь “Талууд” гэх) дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.	

Сумын Засаг дарга _____

1 | 3

Компани _____

1.2. Энэхүү гэрээ нь Говь-Алтай аймгийн нутагт Ашигт малтмалын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу олгосон тусгай зөвшөөрөл эзэмшигч байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.3. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн MV-021169 дугаартай ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд орших газрын байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, орон нутгийн иргэдийн амьдрах орчныг сайжруулах, ажлын байр нэмэгдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор талууд хамтран ажиллана.

ХОЁР. ЗАСАГ ДАРГЫН ЭРХ, ҮҮРЭГ

2.1. Энэхүү гэрээний хүрээнд Засаг дарга дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

2.1.1. Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал ашиглах үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах;

2.1.2. Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд танилцуулж, санал авах;

2.1.3. Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт, хэлэлцүүлэг зохион байгуулж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан төсөл, арга хэмжээнээс тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй хамтран хэрэгжүүлэх боломжтой төсөл, арга хэмжээг сонгож, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй зөвшилцсөний үндсэн дээр энэ тухай иргэдэд мэдээлэх;

2.1.4. Тусгай зөвшөөрөл эзэмшигчээс сум орон нутагт хуваарилах, санхүүжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахтай холбогдсон журмыг боловсруулан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан мөрдөж ажиллах;

2.1.5. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг иргэдэд хүргэн ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулах;

2.1.6. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих;

2.1.7. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт, шаардлагыг хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэж, зохих хариуг өгөх;

2.1.8. Тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд сум орон нутаг, төрийн байгууллагын албан хаагчид болон иргэдийн зүгээс хууль бус дарамт шахалт үзүүлэх асуудлыг таслан зогсоох, буруутай этгээдэд хариуцлага тооцох


2.1.9. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хуулийн олгогдсон эрх, боломжоо хэрэгжүүлэх, төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хуульд заасан дэмжлэгийг үзүүлэх.

ГУРАВ. КОМПАНИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1. Ерөнхий:

3.1.1. Үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулахад орон нутгийн иргэн, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруулсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу аймаг, сум, багийн Засаг дарга, түүний Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн/Нийтийн Хуралд тавьж шийдвэрлүүлэх;

3.1.2. Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газартай хамтарч ажиллаж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлах;



3.1.3. Хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны сургалтын хөтөлбөр боловсруулж, тухайн орон нутгийн иргэдийг хамруулах ажлыг зохион байгуулах;

3.1.4. Нийт ажлын байрны 10-аас доошгүй хувьд тухайн орон нутгийн иргэдийг зохих түвшний сургалтад хамруулсны үндсэн дээр ажиллуулах;

3.1.5 Орон нутгийн оюутан залуусыг дадлага хийх нөхцөл боломжоор хангах

3.1.6. Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг сумын ЗДТГ, аймгийн ХХҮГ-т бүртгүүлэх;

3.1.7. Хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээ болон үйл ажиллагааныхаа талаар аймаг, сумын иргэдэд тогтмол буюу сар бүр мэдээлэл өгч байх;

3.1.8. Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд эхний ээлжинд давуу эрх олгох;

3.1.9. Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан байгаль орчныг хамгаалах ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг биелүүлж ажиллах;

3.1.10. Гамшгийн үед сайн дурын үндсэн дээр тухайн орон нутагт техник, тоног төхөөрөмж, ажиллах хүчний болон бусад материаллаг туслалцаа үзүүлэх.

3.1.11 Тусгай зөвшөөрөл эзэмшигч, түүний туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжүүдийг орон нутгийн Татварын хэлтэст татвар төлөгчөөр бүртгүүлж, холбогдох хуулийн дагуу орон нутгийн дагуу орон нутгийн төсөвт төвлөрүүлэх, татварыг хугацаанд нь бүрэн төвлөрүүлэх;

3.2. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиглэлээр:

3.2.1. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь Монгол Улсын Үндсэн хууль, Байгаль орчныг хамгаалах, Газрын тухай, Татварын тухай, Нийгмийн даатгалын тухай багц хуулиуд, Ашигт малтмалын тухай, Газрын хэвлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

3.2.3. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хуульд заасан хувь хэмжээгээр ажиллуулаагүйтэй холбоотой төлбөрийг Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу аймгийн Хөдөлмөр эрхлэлтийн санд бүрэн төвлөрүүлэх.

3.3. Орон нутгийн хөгжлийг дэмжих чиглэлээр:


3.3.1. Говь-Алтай аймгийн хөгжилд тодорхой хувь нэмэр оруулж, боломжтой дэмжлэг, туслалцааг үзүүлнэ;

3.3.2. Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хавсралтад тусгагдсан арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ.

3.4. Байгаль хамгаалах чиглэлээр:

3.4.1. Үйлдвэр, уурхайн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө болон тайланг олон нийтэд танилцуулж, уурхайн үйл ажиллагааны тухай нутгийн иргэдийг мэдээллээр хангах ажлыг тухай бүр нь аймаг, сумын Засаг дарга, түүний Тамгын газартай хамтран зохион байгуулж ажиллана.

3.4.2. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон төлөвлөгөөний дагуу үйлдвэр, уурхайн орчин, замын маршрутын дагуу хөрс, ургамал, булаг шанд, гол горхи, ан амьтан хамгаалах, худаг, уст цэг гаргах ажлыг зохион байгуулж холбогдох нөхөн сэргээлтийг хийх;



19 10042

3.4.3. Туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдийн байгаль орчныг хамгаалах менежментийн төлөвлөгөө, тайланд хяналт тавьж ажиллах;

3.4.4. Байгалийн нөөц ашигласны төлбөрийг тухайн үед мөрдөгдөж байгаа хууль, эрх бүхий байгууллагаас баталсан тарифын хэмжээгээр тооцож, орон нутгийн төсөвт төлөх ба ус ашиглах нөхцөл нь бусад ус ашиглагчтай адил байна.

3.5, Дэд бүтцийн чиглэлээр:

3.5.1. Уурхай орчмын бүс нутгийн дэд бүтцийг сайжруулах зорилгоор уурхай орчмын орон нутгийн чанартай автозамыг засаж сайжруулах;

ДӨРӨВ. ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХОРОО

4.1. Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "хороо" гэх)-г аймаг, сумын Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

4.2. Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг багийн иргэдийн Нийтийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

4.3. Хороо нь гэрээний хэрэгжилтийн талаарх тайланг тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тайланг батлуулахаас өмнө аймаг, сумын Засаг даргад тухайн жилийн 11 дүгээр сарын 20-ны дотор хүргүүлнэ.

ТАВ. ГЭРЭЭНИЙ ТАЙЛАГНАЛТ

5.1. Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлэх бөгөөд гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг талуудын цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг, сумын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

5.2. Талууд гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, тайланг дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

5.3. Талууд гэрээний тухайн жилийн биелэлтийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны өдрийн дотор Геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

ЗУРГАА. ГЭРЭЭНИЙ ХАРИУЦЛАГА

6.1. Энэхүү гэрээ нь Талуудын хууль тогтоомжид заасан бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй.

6.2. Талууд гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээнэ.

6.3 Гэрээний аль нэг тал давагдашгүй хүчин зүйл (газар хөдлөлт, үер, гал түймэр, хүчтэй салхи, шуурга, халдварт өвчин, байгалийн бусад аюулт үзэгдэл, хатуу хөл хорио, төрийн оролцоо)-ийн нөхцөл байдлын улмаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй болсон тохиолдолд нөгөө талдаа албан бичгээр мэдэгдэх бөгөөд мэдэгдсэнээр хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болно. Дээрх давагдашгүй хүчин зүйлийн нөхцөл байдал бий болсон тохиолдолд гэрээний үүргийн гүйцэтгэлийг тус нөхцөл байдал арилах хүртэлх хугацаагаар харилцан тохиролцож хойшлуульж болно.

6.4. Гэрээгээр хүлээсэн эрх, үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1. Талууд гэрээний хэрэгжилттэй холбоотой үүссэн маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

7.2. Гэрээний нэг тал нь нөгөө талынхаа үйл ажиллагаатай холбоотой гомдлыг эрх бүхий Төрийн захиргааны байгууллагад гаргаж болно.

7.3. Талууд маргаан, зөрчлийг эв зүйгээр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд Монгол Улсын Шүүхээр шийдвэрлүүлнэ.

НАЙМ. ГЭРЭЭ ХУЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ

8.1. Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш 2021 оны 12 дугаар сарын 31 хүртэл гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

8.2. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

8.3. Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Гэрээнд оруулсан нэмэлт, өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

8.4. Гэрээг Монгол хэл дээр 3 хувь үйлдэнэ. Зайлшгүй тохиолдолд гэрээний хувийг Англи хэл дээр үйлдэж болно.

ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН ЕСӨНБУЛАГ СУМЫГ ТӨЛӨӨЛЖ

Хүлээн зөвшөөрсөн: 

Нэр: А.АЛТАНХУЯГ

Албан тушаал: СУМЫН ЗАСАГ ДАРГА

“БОЛДГЯНТБОЛД” ХХК-ИЙГ ТӨЛӨӨЛЖ

Хүлээн зөвшөөрсөн: 

Нэр: Х.ОЛОНБОЛД

Албан тушаал: ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ

№.....

Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд хамтран ажиллах..... тоот гэрээний хавсралт
2021 оны дугаар сарын

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ЗОРИЛГООР
2021 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

№	Арга хэмжээний нэрс	Биелэлт
1	Уурхайн хэрэглээний мах, хүнсний бүтээгдэхүүн, төрөл бүрийн хүнсний ногоо, шаардлагатай багаж хэрэгсэл, материал худалдан авах, ажиллах хүч сонгохдоо тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдтэй тэргүүн ээлжинд давуу эрхээр гэрээ байгуулах	
2	Уурхайн ажилчдын хөдөлмөр хамгааллын /зуны болон өвлийн улирлын/ хувцсыг аймгийн ажлын хувцасны үйлдвэртэй гэрээ байгуулан хамтарч ажиллах.	
3	Наран багийн Бидэрьяагийн булгийн эхийг хашиж хамгаалах	
4	Ашиглалтын талбай орчмын хууль бусаар ашигт малтмал олборлогчдын үйл ажиллагааны улмаас эвдрэлд орсон 5.4га , 600м2 газруудад техникийн нөхөн сэргээлт хийж, хүлээлгэн өгөх	
5	Нутгийн малчдын хүсэлтийн дагуу худаг ус гаргах, өвөлжөө бууц задлах.	

Сумын Засаг дарга



6 | 3

Компани

